



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 08

Урт


Г Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
даргын нөөц санг зарцуулах журам
батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дахь заалтыг үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын нөөц санг зарцуулах журмыг хавсралтаар баталсугай.

2. Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын нөөц санг журмын дагуу зарцуулахыг Хурлын дарга /Б.Отгонбаяр/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын
тэргүүлэгчдийн 2018 оны 03 сарын 06-ны өдрийн
08 тоот тогтоолын хавсралт



СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДЫН ХУРЛЫН ДАРГЫН НӨӨЦ ХӨРӨНГИЙГ ЗАРЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын нөөц сан нь Төлөөлөгчид, албан хаагчид, төрийн болон төрийн бус байгууллагуудыг дэмжих, шагнаж урамшуулах, улс, аймаг, сумын алдартнууд, өндөр настанд хүндэтгэл үзүүлэх, өрхийн амьжиргаа доогуур иргэдэд тусламж дэмжлэг үзүүлэх, бусад тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд оршино.

Хоёр. Нөөц сангийн зарцуулалт

2.1. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын нөөц сангийн хөрөнгийг хурлын тухайн жилийн төсөвт суулган Хурлын даргын захирамжаар баталгаажуулж зарцуулна.

2.2. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын нөөц хөрөнгийг дараах арга хэмжээнд зарцуулна. Үүнд:

2.2.1. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчид болон хороодыг ажиллахад дэмжлэг үзүүлэх

2.2.2. Хуулийн төсөл, нийгмийн амьдралын чухал асуудлыг ард нийтээр хэлэлцүүлэх, санал асуулга явуулах

2.2.3. Улс, аймаг, бүсийн чанартай уулзалт зөвөлгөөн, сургалт, уралдаан тэмцээнийг зохион байгуулах

2.2.4. Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд олон жил үр бүтээлтэй ажилласан төлөөлөгч болон төрийн албан хаагчдыг шагнаж урамшуулах, тэдэнд буцалтгүй тусламж олгох

2.2.5. Тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан улс, аймаг, сумын алдартнууд, өндөр настанд хүндэтгэл үзүүлэх

2.2.6. Суманд ажиллаж амьдарч байгаа амьдрал ядуу, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүнд өвчтэй иргэн, байгалийн гамшигт өртсөн хүмүүст нэг удаагийн буцалтгүй тэтгэмж, тусламж үзүүлэх

2.2.7. Улс, аймаг, бүсийн чанартай олимпиад, урлаг, спортын чиглэлээр амжилт гаргасан иргэдийг шагнаж урамшуулах

2.2.8. төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах

2.2.9. бусад

Гурав. Нөөц сангийн зарцуулалтанд хяналт тавих

3.1. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид болон Санхүүгийн мэргэжлийн хяналтын алба



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

20/18 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 09

Урт

Сум хөгжүүлэх сангийн тэргүүлэх
чиглэл батлах тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг үндэслэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын жижиг дунд үйлдвэрлэлийн 2018 онд тэргүүлэх чиглэлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.
2. Тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Сум хөгжүүлэх сангийн зөвлөлд даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Сум хөгжүүлэх сангийн орон тооны бус хяналтын зөвлөлд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР



ГУРВАНТЭС СУМЫН ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН 2018 ОНД ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

Нэг. Зорилго

Орон нутгийн онцлог нөөцөд суурилан өрсөлдөх чадвартай зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, тогтвортой үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажлын байр, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд оршино.

Хоёр: Жижиг дунд үйлдвэрлэлийн дараах чиглэлийг дэмжинэ.

1. Хүнсний чиглэлээр

- 1.1 Хүнсний ногоо хатаах, боловсруулах, савлах үйлдвэр
- 1.2 Стандартын хадгалах агуулах, зоорь
- 1.3 Хүлэмжийн тариалалт
- 1.4 Бусад хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл

2. Мал аж ахуйн чиглэлээр

- 2.1 Ноос ноолуур угаах боловсруулах
- 2.2 Арьс нэхий боловсруулах
- 2.3 Сүү цагаан идээ боловсруулах, савлах
- 2.4 Дайвар бүтээгдэхүүн ашиглах
- 2.5 Малын тэжээлийн ургамал үйлдвэрлэх, боловсруулах
- 2.6 Эрчимжсэн мал аж ахуй /сүүний үхэр, ямаа /

3. Хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр

- 3.1 Барилгын туслах материал үйлдвэрлэл / тоосго, шохой гэх мэт/
- 3.2 Ариун цэврийн цаас үйлдвэрлэл
- 3.3 Бэлэн хувцас үйлдвэрлэл
- 3.4 Шахмал болон хөнгөн түлшний үйлдвэрлэл
- 3.5 Хог хаягдал боловсруулах

4. Бусад чиглэлээр

- 4.1 Аялал жуулчлал
- 4.2 Хэвлэх үйлдвэр
- 4.3 Угаалга хими цэвэрлэгээ
- 4.4 Оёдол, нэхмэл, хатгамал
- 4.5 Модон эдлэл сийлбэр
- 4.6 Халуун ус, саун
- 4.7 Нийтийн хоолны үйлчилгээ
- 4.8 Туслах аж ахуй /гахай тахиа гэх мэт/
- 4.9 Бусад засвар үйлчилгээ



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

20 18 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 10

Урт

Цэргийн албыг дүйцүүлэн хаах
иргэдийг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан “Цэргийн албыг дүйцүүлэн хаах журам”-ын 6 дугаар зүйлийн 20-ийн “а” дахь заалтыг үндэслэн сумын Засаг даргын Тамгын газрын дарга Ц.Дэлгэрмаагийн саналыг хэлэлцээд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Тус сумаас 2018-2020 онд Цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэдийн нэрсийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Энэ тогтоолыг холбогдох материалын хамт аймгийн Засаг даргад хүргүүлэхийг сумын Засаг дарга /О.Баттогтох/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2018 оны 10 тоот
тогтоолын хавсралт



**Цэргийн дүйцүүлэх алба хаах
иргэдийн нэрсийн жагсаалт**

№	Овог нэр	Регистрийн дугаар	Багийн харъяалал
1	Батцэнгэлийн Гантөмөр	КГ96111117	Гоёот баг
2	Цогтбаатарын Содоо	КГ93011017	Гоёот баг
3	Эрдэнэбатын Мөнхбилэг	КЮ96091414	Баясах баг
4	Лхагвасүрэнгийн Хишигбаяр	КГ96032512	Тост баг



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

20 18 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 11

Урт

Амьжиргааг дэмжих зөвлөлийг
шинэчлэн батлах тухай

Монгол улсын Нийгмийн халамжийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3, 27.5 дахь заалтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын Амьжиргааг дэмжих зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй баталсугай.

Үүнд: Зөвлөлийн дарга: Д.Гантулга - Засаг даргын орлогч

Гишүүд: Ц.Цэвэлсүрэн – Дотоод ажил, Нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Э.Алдарбаяр- Нийгмийн даатгалын байцаагч

Н.Дэлгэрмаа - Эрүүл мэндийн төвийн эмч

Ч.Баттогтох - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны төлөөлөл

Л.Жаалхүү - Ахмадын холбоог төлөөлөл

Нарийн бичгийн дарга Н.Цэрэннадмид - Хөдөлмөр эрхлэлт халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Халамжийн тухай хууль амьжиргааг дэмжих зөвлөлийн дүрмийг хэрэгжүүлж ажлын тайланг бүтэн жилээр иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг зөвлөлд даалгасугай

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 01 сарын 19-ны өдрийн 05 тоот тогтоолыг хүчингүйд тооцсугай.



ХУРЛЫН ДАРГА

Б.ОТГОНБАЯР



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 12

Урт

Төрийн дээд шагналд
тодорхойлох тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.15 дахь заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Тус сумын “Хөгшөө” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга Лхагвагийн Төмөртогтохыг “Хөдөлмөрийн хүндэт” медалиар шагнуулах саналыг дэмжсүгэй.

2. Шагнуулахаар тодорхойлсон материалыг холбогдох дээд байгууллагад уламжлахыг сумын Засаг дарга /О.Баттогтох/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР



**ӨМНӨГОВЬ АЙМАГ
ГУРВАНТЭС СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

20 18 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 13

Урт

Сумын 2018 оны Газар зохион
байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт
оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.14, Газрын тухай хуулийн 20.1.2 дахь заалтыг үндэслэн Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. Сумын 2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулсан төлөвлөгөөг хавсралтаар батласугай.
2. Сумын 2018 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулсан талаар аймгийн Газрын албанд уламжилж, нэмэлтээр олгох газарт зохион байгуулалт хийж, хууль тогтоомж болон сумын Ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу олгохыг сумын Засаг дарга /О.Баттогтох/-д даалгасугай.
3. Уг тогтоолыг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаанд танилцуулахыг Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга /Б.Отгонбаяр/д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.ОТГОНБАЯР

